

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Л.Наранчимэг*

Хураангуй

Монголын улсын аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн өнөөгийн төлөв байдлыг СнЯ-ны нягтлан бодох бүртгэлийн газраас нэгтгэн гаргадаг “аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн нэгтгэл”-ийн тоо мэдээ болон статистикийн мэдээлэлд тулгуурлан судалж нийт аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн болон хөдөлмөрийн бүтээмжийн өнөөгийн төлөв байдал, хөгжлийн төлөв хандлага онцлогийг тодорхойлж, тоон болон чанарын судалгаа хийж эргэлтэнд оруулах, улмаар тайлангийн мэдээллийн үнэн зөв, нээлттэй байдлыг хангахад Нягтлан бодох бүртгэл, тайлагналын үүргийг дээшлүүлэх талаар санал дүгнэлт гаргахыг зорьсон болно.

Түлхүүр үгс: Аж ахуйн нэгж байгууллага, нийт хөрөнгийн хэмжээ, борлуулалтын орлого, хөрөнгө, өр төлбөр, эзний өмч

Abstract

The study aims to define the financial situation of Mongolian entities. The objective of research determines the nature of its trend and evaluate the role of accounting and its reporting by reviewing the accuracy and transparency of the reporting information by making analysis including core financial indicators. This research consists a number of qualitative and quantitative analysis. The analysis was conducted to determine the target balance to meet the minimum level of financial indexes for mining companies using mathematical methods. The data including during year of 2013-2018 is based on the “Financial statements of the entities” issued by the Accounting policy department, Ministry of Finance of Mongolia and related statistical information. The significance of the study will be more useful to understand a Mongolia’s entities financial nature and make better economic decisions.

Key words: Business entities, total assets, sales revenues, assets, liabilities, equity

* МУИС, Бизнесийн Сургууль (E-mail): naranchimeg_L@num.edu.mn

Монголын улсын аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн өнөөгийн төлөв байдлыг СнЯ-ны нягтлан бодох бүртгэлийн газраас нэгтгэн гаргадаг “аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн нэгтгэл”-ийн тоо мэдээ болон статистикийн мэдээлэлд тулгуурлан судалж онцлогийг тодорхойлох, улмаар мэдээллийн үнэн зөв, нээлттэй байдлыг хангахад Нягтлан бодох бүртгэл, тайлагналын үүргийг дээшлүүлэх талаар санал дүгнэлт гаргахыг зорьсон болно.

НЭГ. Тайлангийн нэгтгэлийн талаар

Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй” гэсэн 9.1 дэх заалт болон Сангийн сайдын 2017 оны 243 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, мэдээллийг ашиглах журам”-ын 3.1 дэх заалт “харилцагч санхүүгийн байгууллага нь хуульд заасан хугацаанд илгээсэн аж ахуйн нэгж байгууллагын улирлын болон жилийн санхүүгийн тайланг ажлын 15 өдрийн дотор хянаж, хүлээн авна” гэж заасны дагуу хүлээн авч баталгаажуулж байна.

Монгол улсын хэмжээнд 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нийт 113 901 аж ахуйн нэгж байгууллага тушаахаас 89204 ААНБ тушааж, тайлангийн ирц 78,3 хувьтай гарсан байна.

Тайлангийн нэгтгэлд хамрагдсан байгууллагууд:

Хүснэгт 1 Судалгааны нэгтгэлд хамрагдсан байгууллагууд

Он	ХХК	ХК	Бусад	ТББ	ББСБ	МУЦБ	ХЗХ	Банк	Даатгал	Нийт
2011		52510		3183			233			60198
2012		58449		3909			192			67381
2013		66767		4111	270	77	120	17	13	71375
2014		72859		5579	348	67	190	18	14	79075
2015		77508		6447	390	67	215	17	14	84658
2016		79058		6759	430	48	226	17	16	86564
2017		81091		7319	459	55	247	16	17	89204

Эх сурвалж: Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн нэгтгэл 2007-2017

Монгол улсад үйл ажиллагаа явуулахаар бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо жилээс жилд дунджаар 5-11 хувиар нэмэгдэж байна. 2018 оны 2-р улирлын байдлаар нийт 163100 аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй, үүний 51 хувь буюу 83086 аж ахуйн нэгж л үйл ажиллагаа явуулж байна. Үлдэж байгаа аж ахуйн нэгжүүд нь (49 хувь нь) үйл ажиллагаа явуулаагүй, эрхлээгүй, түр зогсоосон, үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон байна.

Монгол улсын үндэсний статистикийн төв хорооноос гаргасан “Аж ахуйн нэгж байгууллагын тоо, бүтцийн өөрчлөлтийн дүн шинжилгээнд” үйл ажиллагаа явуулж

буй аж ахуйн нэгж байгууллагын тоо өнгөрсөн 10 жилийн хугацаанд 40.1 мянга буюу 2.2 дахин нэмэгдэхэд:

Хариуцлагын хэлбэрийн хувьд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тоо 34.8 мянга буюу 2.8 дахин, төрийн бус байгууллагын тоо 4.4 мянга буюу 2.4 дахин өссөн,

Өмчийн хэлбэрийн хувьд төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын тоо 39 буюу 81.3 хувиар буурч, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын тоо 37.8 мянга буюу 2.5 дахин өссөн,

Ажиллагчдын тооны бүлгийн хувьд 1-9 ажиллагчидтай жижиг аж ахуйн нэгж, байгууллагын тоо 35.0 мянга буюу 2.4 дахин өссөн,

Эдийн засгийн салбарын хувьд үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо 4.3 мянга буюу 2.7 дахин, барилгын салбарынх 4.8 мянга буюу 4.9 дахин, худалдааны салбарынх 16.3 мянга буюу 2.4 дахин өссөн,



Аймаг, нийслэлийн хувьд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо 27.0 мянга буюу 2.4 дахин, Ховд аймагт 1.1 мянга буюу 2.5 дахин, Хөвсгөл аймагт 1.1 мянга буюу 3.2 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна. Эндээс харахад өнгөрсөн 10 жилийн хугацаанд Улаанбаатар хотод цөөн тооны ажилтантай барилга болон худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тоо мэдэгдэхүйц нэмэгдсэн нь эдийн засагт жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллага зонхилж буйг илтгэж байна.

2017 оны 4-р улирлын байдлаар нийт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 4,4 хувь буюу 3 917 байгууллага нь ХАА нь салбарт, 8,8 хувь буюу 7 293 нь аж үйлдвэрийн салбарт, 8,1 хувь буюу 6 760 нь барилгын салбарт, 39,1 хувь буюу 32 489 нь худалдааны салбарт, 39,3 хувь буюу 32 627 байгууллага нь үйлчилгээний салбарт тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгжийн 78,4 хувь буюу 65116 аж ахуйн нэгж байгууллага (ААНБ) нь худалдаа үйлчилгээний чиглэлээр ажиллаж байна. 1- 9 ажилагчидтай ААНБ 85,8, 10-19 ажиллагчидтай 6,3 хувь, 20-49 ажиллагчидтай 4,9 хувь, 50 дээш ажиллагчидтай 3 хувийг тус тус эзэлж байна. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй байгууллагын дийлэнх нь буюу 86 орчим хувь 1-9 ажиллагчидтай худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд байна. 2019 оны нягтлан бодох бүртгэлийн улсын үзлэгийн дүнгээс харвал санхүү, бүртгэл хариуцан ажиллаж буй нийт 18,943 мэргэжлийн нягтлан бодогч байгаа бол үүний 90 хувь буюу 15,467 нягтлан бодогч аж ахуйн нэгж байгууллагад, 10 хувь буюу 3476 нягтлан бодогч төсөвт байгууллагад ажиллаж байна. Үүнээс бакалаврын зэрэгтэй 15,645 хүн, магистрын зэрэгтэй 3,215 хүн, доктор 83 хүн байна. Эмэгтэй нягтлан бодогч 72 хувийг эзэлж байна¹.

¹ Бүртгэл санхүү эдийн засгийн ажилтны улсын IV зөвөлгөөн “НББ-ийн стандартын хэрэглээ-Мэргэжилтэн өнөө ба ирээдүй илтгэл



2018 оны 4-р улирлын тоон мэдээнээс үзвэл 1-9 ажиллагчидтай жижиг аж ахуйн нэгжийн тоо өсч, бусад аж ахуйн нэгжийн эзлэх хувь буурсан байна. Нийт нэгтгэлд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагыг нийт хөрөнгө болон борлуулалтын орлогын хэмжээгээр нь шатлан ангилан үзүүлбэл:



Дээрх зураглал (диаграмм)-аас үзэхэд 500,0 сая төгрөг хүртэлх хөрөнгө, 1,5 сая төг хүртэлх борлуулалтын орлоготой байгууллагын тоо нийт ААНБ-ын 91-94 хувийг эзэлдэг боловч нийт хөрөнгийн 2 хувь, борлуулалтын орлогын 10 хувийг л бүрдүүлж, харин том аж ахуйн нэгжүүд тооны хувьд цөөхөн (14-21%) боловч хөрөнгийн 98%, орлогын 90%-ийг бүрдүүлж тэдгээрийн үүрэг оролцоо сүүлийн 6 жилд нэмэгдэх хандлагатай болжээ.

Нийт аж ахуйн нэгжийн 84 хувь нь 0-100,0 сая төгрөгний борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд байгаагаас үзвэл манай аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь жижиг нэгжүүд байна. Хөрөнгийн болоод борлуулалтын орлогын хувьд жижиг аж ахуйн нэгжүүдийн хувийн жин 2017 онд буурч, дунд болон томоохон нэгжүүдийн хувь оролцоо өсөх хандлагатай болжээ.

ХОЁР. Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн төлөв байдлын судалгаа

Хүснэгт 2. Хөрөнгө, эх үүсвэрийн бүтэц, 2013-2017, хувиар

Үзүүлэлтүүд	2013	2014	2015	2016	2017	2013-2017 оны дундаж	
						х/жин	өсөлт %
Хөрөнгийн бүрэлдэхүүн							
Эргэлтийн хөрөнгө	63.7	63.4	50.9	61,5	53,9	58,7	111,9
Эргэлтийн бус хөрөнгө	36.3	36.6	49.1	38,5	46,1	41,3	124,1
Нийт хөрөнгө	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	116,8
Санхүүжилтийн бүрэлдэхүүн							
Богино хугацаат өр төлбөр	58.0	57.3	54.0	50.5	44,1	52,8	109,2
Урт хугацаат өр төлбөр	20.0	20.5	19.0	22.9	15,8	19,6	109,2
Нийт өр төлбөр	78.00	77.80	73.0	73.4	59,9	72,4	109,2
Эздийн өмч	22.00	21.20	27.0	26.6	40,1	27,6	136,3
Нийт эх үүсвэр	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	116,8

Эх сурвалж: СнЯ “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн нэгтгэл 2011- 2017”

Аж ахуйн нэгж байгууллагын сүүлийн 5 жилийн дунджаар тооцоход нийт хөрөнгийн 58,7 хувийг эргэлтийн хөрөнгө, 41,3 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж, сүүлийн жилүүдэд (2013-2017 онд) эргэлтийн хөрөнгийн эзлэх хувийн жин буурах хандлагатай байгаа нь хөрөнгийн хөрвөх чадвар болон, эргэцэд сөрөгөөр нөлөөлсөн байна.

2013 оноос хойш аж ахуйн нэгж байгууллагын нийт хөрөнгө 78 254 тэрбум төгрөгөөс 145 745 тэрбум төгрөг болж 86,2 хувиар өссөн ба 2017 онд гэхэд л өмнөх оноос 2 640,0 тэрбум төгрөг буюу 3,0 хувиар өссөн байна. Гэхдээ хөрөнгийн зонхилох өсөлт 2012-2013 онд бий болсон бөгөөд дараагийн онуудад өсөлт тогтворжиж, 2017 онд эргэлтийн бус хөрөнгө огцом нэмэгдсэн (55,0 хувиар) нөхцөл байдлыг харгалзан 2013-2017 оны дундажаар тооцоход нийт хөрөнгийн 58,7 хувийг эргэлтийн, 41,3 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

2017 оны гүйцэтгэлээр санхүүжилтын 72,4 хувийг өр төлбөр, 27,6 хувийг өөрийн хөрөнгө эзэлж, нийт санхүүжилтанд өөрийн хөрөнгийн оролцоо сүүлийн 3 жил дараалан нэмэгдсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллагын нийт өр төлбөрийн 52,8 хувийг богино хугацаат өр төлбөр, 19,6 хувийг урт хугацаат өр төлбөр бүрдүүлж байна.

Хүснэгт 3. Матриц хэлбэрийн баланс /тэрбум. төгрөг/

Пассив Актив	БХӨ		УХӨ		Эзний өмч		Баланс	
	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017
ЭХ-ийн хувьсах хэсэг:	56,909	64,272					56,909	64,272
ЭХ-ийн тогтмол хэсэг					12,379	14,241	12,379	14,241

Эргэлтийн бус хөрөнгө			25,795	22,991	17,547	44,241	43,342	67,232
Баланс	56,909	64,272	25,795	22,991	29,926	58,482	112,630	145,745

Аж ахуйн нэгж байгууллагуудын дүнгээр хөрөнгө, эх үүсвэрийн зэрэгцүүлсэн балансаас харахад эргэлтийн хөрөнгийн хувьсах 100% богино хугацаатай зээл, өр төлбөрөөр, эргэлтийн хөрөнгийн тогтмол хэсгийн 41% хувь өөрийн хөрөнгөөр (2016 онд) санхүүжигдэж байсан бол 2017 онд 24,3 хувь бол өөрийн хөрөнгийн санхүүжилт багасан байна.

Он	Хөрөнгийн эх үүсвэр	Хөрөнгө
2016 он	Богино хугацаатай өр төлбөр (100%)	Эргэлтийн хөрөнгийн хувьсах хэсэг
2017 он	Богино хугацаатай өр төлбөр (100%)	Эргэлтийн хөрөнгийн хувьсах хэсэг
2016 он	Урт хугацаатай өр төлбөр (100%)	Эргэлтийн бус хөрөнгө
2017 он	Урт хугацаатай өр төлбөр (100%)	Эргэлтийн бус хөрөнгө
2016 он	Эзний өмч (41,0 %) Эзний өмч (59,0 %)	Эргэлтийн хөрөнгийн тогтмол хэсэг Эргэлтийн бус хөрөнгө
2017 он	Эзний өмч (24,3 %) Эзний өмч (75,7 %)	Эргэлтийн хөрөнгийн тогтмол хэсэг Эргэлтийн бус хөрөнгө

Урт хугацаатай зээл, өр төлбөр 100%, өөрийн хөрөнгийн 24,3-75,7 хувийг тус тус эргэлтийн бус хөрөнгийн санхүүжилтэнд зориулагдаж байна.

Хөрөнгө болон өр төлбөрийн хувийн жинг ААНБ-ын хэмжээгээр нь (жижиг, дунд, том гэх мэт) ангилан судалбал зохимжтой хэдий ч тайлангийн нэгтгэлээр хараахан тийм мэдээлэл гаргаагүй тул байгаа мэдээлэлд суурилан ААНБ-ын хэлбэрээр нь тооцоход 2016 оны байдлаар нийт хөрөнгийн 71,0 хувь нь хувьцаат болон хязгаарлагдмал хариуцлагатай компаниудад, 27,0 хувь нь арилжааны банкууд болон банк бус санхүүгийн байгууллагууд байршин үйлдвэрлэл үйлчилгээ, орлого бүтээхэд ашиглагддаг бол нийт өр төлбөрийн 69,0 хувь нь компаниудад, 27,4 хувь нь арилжааны банкуудын тэр дундаа урт хугацаат өрийн 98,8 хувь нь зөвхөн компаниудад ногдож байна.

2013-2017 онуудын дундажаар тооцоход нийт хөрөнгийн өсөлтийн бараг 2/3 буюу 64,5 хувийг өр төлбөрийн өсөлтээр (тэр дундаа 72,8 хувийг БХӨ-өөр), үлдэх 35,5 хувийг эздийн өмчийн өсөлтээр тус бүр хангасан байна. Тэгэхдээ нийт санхүүжилтэнд өр төлбөрийн оролцоо буурч, өөрийн хөрөнгийн хувийн жин нэмэгдэх хандлагатай байгаа нь бизнес эрхлэгч компаниудын санхүүгийн бие даасан байдал сайжирсаныг (ялангуяа 2014-2015 онд) илтгэж байна. Ийнхүү 2017 оны эцсийн байдлаар нийт хөрөнгийн 53,9 хувь нь эргэлтийн бус хөрөнгө, нийт хөрөнгийн санхүүжилтын 59,9 хувь нь өр төлбөр байгаа боловч өөрийн хөрөнгийн оролцоо 40,1 хувь болж өмнөх онуудаас 5,5 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь бас нөгөө талдаа урт хугацаат төлбөрийн санхүүжилт дутагдалтай байдлаас болоод өөрийн хөрөнгийн багагүй хэсгийг эргэлтийн бус хөрөнгийн санхүүжилтэнд зарцуулснаас болоод хөрөнгийн хөрвөх чадвар буурч, өөрийн эргэлтийн хөрөнгийн хангамжид сөрөгөөр нөлөөлж байгааг анхаарахгүй байж болохгүй.

Сүүлийн 3 жилийн дундажаар тооцоход ААНБ-ын нийт хөрөнгийн санхүүжилтын $\frac{3}{4}$ буюу 76 хувийг урт ба богино хугацаат өрөөр, 24 хувийг өөрийн хөрөнгөөр бүрдүүлж, өөрийн хөрөнгийн өсөлт илүү хурдацтай байгаа (136,3% > 109,2%) сайшаалтай юм.

Аливаа бизнесийн байгууллагын үйл ажиллагааны далайц, өсөлтийн чиглэлийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний тоо хэмжээ, нэр төрөл, борлуулалтын орлогод тэдгээрийн эзлэх хувийн жингээр тодорхойлохоос гадна эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн өсөлтийн динамик шинжилгээг тодорхой эрэмбэ дарааллаар нь хийх нь арга зүйн хувьд зохимжтой байдаг.² Хөрөнгө эх үүсвэрийн бүтэц бүрэлдэхүүн, тэдгээрийн өсөлтийн хурд буюу үндсэн үзүүлэлтүүдийн өсөлтийн нормативт харьцаа нь $\text{ӨК} > \text{ЭБ} > \text{НХ} > \text{ЭХ} > \text{ГК}$ байвал зохимжтой гэж Оросын эрдэмтэд тодорхойлжээ.³ Тэгэхдээ өсөлтийн харьцааны норматив нь санхүүгийн тогтвортой байдлын өндөгөөс харсан хамаарал бөгөөд оруулсан хөрөнгийн ашиглалт өгөөжийн талаас нь үзвэл өөр байж болох талтай. Өсөлтийн харьцааг зэрэгцүүлэхдээ зөвхөн тайлант оных төдийгүй өмнөх 3-5 жилийн дундаж өсөлтөөр нь тооцвол ерөнхий дүр зураг харагдах боломж илүү байж болох юм.

Хүснэгт 3. ААНБ-ын үндсэн үзүүлэлтүүдийн өсөлтийн хурд

Үзүүлэлтүүд		Өөрийн хөрөнгө	Эргэлтийн бус хөрөнгө	Нийт хөрөнгө	Эргэлтийн хөрөнгө	Нийт өр төлбөр
Нормативт зэрэглэл (R)		1	2	3	4	5
Тайлангийн нэгтгэлээр	2016 оны өсөлт, бууралт	195,5 (1)	155,1 (2)	129,4 (3)	113,3 (4)	105,5 (5)
	Өнгөрсөн 4 жилийн дундаж өсөлт	120.9 (1)	115.2 (2)	112.9 (3)	111.6 (4)	110.5 (5)

Санхүүгийн тайлангийн нэгтгэл буюу нийт ААНБ-ын дүнгээр болон компаниудаар тооцоолоход үндсэн үзүүлэлтүүдийн өсөлтийн харьцаа нь төдийлэн ялгагдахааргүй $\text{ЭБХ} > \text{ӨК} > \text{НХ} > \text{ГК} > \text{ЭХ}$ болж үзүүлэлт тус бүрийн өсөлтийн зэрэглэл нормативаас нилээд өөр, тухайлбал эргэлтийн бус хөрөнгийн өсөлт давамгайлсан, тэр өсөлтийн багагүй хэсгийг өөрийн хөрөнгө (эздийн өмч)-ийн өсөлтөөр хангасан нийтлэг дүр зэрэг харагдаж байна. Энэ нь зөвхөн компаниудад төдийгүй санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдсан нийт ААНБ-уудад түгээмэл юм байна. 2017 оны гүйцэтгэл болон 2013-2017 оны дундаж өсөлтийн хувь хэмжээ нь ялгаатай хэдий ч ерөнхий хандлага нь ялгагдахааргүй гарсан нь өнгөрсөн 3 жилийн дундаж өсөлтөнд 2017 оны гүйцэтгэлийн өсөлтийн нөлөөлөл их байсантай холбоотой юм.

Эдгээрээс ерөнхийд нь дүгнэвэл ААНБ-уудын нийт санхүүжилтын 60 гаруй хувийг өр төлбөрөөр нөхөж байгаа хэдий ч бизнесийн хөрөнгө оруулалтын өсөлтийг хангахад гадаад эх үүсвэрийн тэр дундаа урт хугацаат санхүүжилтын олдоц хангалттай

² Б. Сайнжаргал “Санхүүгийн тайлангийн шинжилгээ” УБ хот 1999 он

³ Савицкая Г.В, Москва 2006, Методика комплексного анализа хозяйственной деятельности Изд- во Проспект, Москва

бусын нөлөөгээр нэмэгдсэн өөрийн өмчөө эргэлтийн бус хөрөнгийн санхүүжүүлэхэд зарцуулан хөхвөх чадваргүй болгодог байдал ажиглагдаж байна.

Гурав. Аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн үзүүлэлтүүдийн судалгаа

Санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдсан нийт ААНБ-ын дүнгээр 2017 онд 53 775,0 тэрбум төгрөгийн борлуулалтын болон хүүний орлого олж 4 076,0 тэрбум төгрөгийн (орлогын төгрөг тутмаас 7,58 мөнгөний) ашигтай ажиллажээ.

Борлуулалтын орлого түүнд хамаарагдах борлуулсан бүтээгдэхүүний өртөг, борлуулалтын болон ерөнхий удирдлагын зардлын (үйл ажиллагааны зардал) бүтцийг нийт ААНБ-ын дүнгээр болон компаниудаар зэрэгцүүлэн судалж үзлээ.

Хүснэгт 4. Нийт ААНБ-ын орлого, үр дүнгийн бүтэц

Үзүүлэлт	Хувийн жин					2013-2017 оны дундаж	
	2013	2014	2015	2016	2017	Хувийн жин	Жил тутмын өсөлт, %
1.Борлуулалтын болон хүүний орлого	100	100	100	100	100	100	113,5
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	73,7	74,0	72,8	74,9	71,8	73,4	112,7
3.Борлуулалтын ба удирдлагын зардал	20,1	22,3	23,7	28,7	25,8	24,1	120,7
4.Үндсэн ажиллагааны ашиг (алдагдал)	6,2	3,7	3,5	-3,7	2,7	2,5	89,3
5. Татварын өмнөх ашиг (алдагдал)	1,1	1,8	1,0	-5,7	7,6	1,2	184,4
6.Татварын дараах ашиг (алдагдал)	(1,3)	(0,9)	(3,2)	-6,0	5,5	1,2	163,8

Хүснэгт 5. Санхүүгийн үндсэн (харьцаа) үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2013	2014	2015	2016	2017	5 жилийн дундаж
1.Бие даалтын коэффициент	21,6	22,2	26,7	26,5	40,1	2,85
2.Зохицуулалтын коэффициент	27,8	27,1	-12,9	41,3	24,4	20,6
3.Өр төлбөрийн харьцаа	3,62	3,51	2,74	2,76	1,49	2,47
4.Эргэлтийн хөрөнгийн харьцаа	1,1	1,1	0,94	1,22	1,22	1,11
5.Нийт хөрөнгийн өгөөж, %	2,55	1,4	1,04	-1,26	0,87	0,79
6.Өөрийн хөрөнгийн өгөөж %	2,08	3,13	1,05	-1,97	6,96	2,25

ААНБ-ууд болон компаниудын **бие даалтын коэффициент** буюу өөрийн санхүүжилтын оролцоо жилээс жилд нэмэгдэх хандлагатай хэдий ч сүүлийн 5 жилийн дундажаар 21,0-40,1 болж нэмэгдэж, гадаад эх үүсвэрийн хараат байдал 79,0-60,9 хувь болж буурсныг илэрхийлж байна.

Өөрийн эргэлтийн капиталын зохицуулалт буюу эргэлтийн хөрөнгийн санхүүжүүлэлтийн оролцоо нь 2013-2014 онд 26,9-27,8 хувь байсан нь 2015 онд богино хугацаат өрийн өсөлтээс хамааран эрс буурч, сөрөг утгатай болсон нь ААНБ-уудын санхүүгийн байдал улам бүр хүндэрч, эргэлтийн хөрөнгийн хувьд 100 хувь зээлийн хараат байдалд орсоньг илтгэж байсан болов 2016-2017 онуудад нэмэгдэж эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэнд өөрийн хөрөнгийн оролцоо 5 жилийн дундажаар 20,6 хувь болжээ.

Өөрийн санхүүжилтын оролцоо бага ч гэсэн нэмэгдэж байгаагийн нөлөөгээр төлөв нь өрийн харьцаа буурах хандлагатай байна.

Эргэлтийн хөрөнгийн харьцаа ААНБ-уудад 0,94-1,2 байгаа нь шаардлагатай хэмжээнээс 100 хувь (бараг 2 дахин) доогуур байгаа нь байгууллагуудын төлбөрийн чадвар хангалттай бус байгааг илтгэж байна.

Оруулсан хөрөнгийн өгөөж 5 жилийн дундажаар тооцоход нийт хөрөнгийнх 0,79%, өөрийн хөрөнгийнх 2,25 % байгаа нэн чамлагдахаар хэмжээ бөгөөд жил дараалан буурсаар 2015, 2016 онд өөрийн хөрөнгийн өгөөж бүр сөрөг утгатай болжээ.

Эдгээрээс бүхэлд нь дүгнэвэл улс орны эдийн засаг санхүүгийн хүндрэлийг даван туулахын тулд нийт аж ахуй эрхлэгч байгууллага тэр дундаа орлогын 80 гаруй хувийг бүтээж, ажлын байраар хангаж байгаа хувьцаат болон ХХК-иудын эргэлтийн хөрөнгийн санхүүжилтыг нэмэгдүүлэх, зээлийн хүү болон татвар шимтгэлийн дарамтыг бууруулах, орлогын хуваарилалтаар өөрт нь үлдэх хэмжээг нэмэгдүүлэх замаар санхүүгийн хараат бус (бие даасан) байдлыг бэхжүүлэх шаардлага нэн түрүүнд тавигдаж байгааг бидний судалгаа харуулж байна.

Дөрөв. Хөрөнгө, эх үүсвэрийн зохистой бүтэц (Төлөөлсөн салбараар)

Монголын уул уурхайн салбарын компаниудын санхүүгийн өнөөгийн төлөв байдлын судалгаанаас үзэхэд Монголын эдийн засагт уул уурхайн салбарын хувийн жин өсөж, эдийн засгийн өсөлтөнд эерэг нөлөөллийг үзүүлж байгаа хэдий ч уул уурхайн салбарын компаниудын санхүүгийн төлөв байдал нь тогтворгүй, нийт өрийн харьцаа өндөр, хөрөнгийн ашиглалт, өгөөж сайнгүй байна. Бид судалгаандаа уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 19 компани сүүлийн 3 жилийн тоо мэдээг ашиглан тооцоо судалгаа хийхийг зорьлоо. Сүүлийн 3 жилийн татварын мэдээллээс Монгол улсын хэмжэээнд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн салбарын компаниудын улсын төсөвт төвлөрүүлсэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 92-96%, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 87-95% ийг бидний судалгаанд хамрагдсан 19 компани төвлөрүүлжээ.

Бид уул уурхайн компаниудын дундажаар санхүүгийн үзүүлэлтүүдийн минимум түвшинг хангах зорилтот балансыг тодорхойлохын тулд дараах хязгаарлалтуудыг хангана гэсэн зорилт тавьлаа⁴.

1. $\min(\delta_1 x_1 + \delta_2 x_2)$
2. $x_1 + x_2 \geq 2БХӨ - ЭХ$

⁴ Л.Наранчимэг “Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээний онол арга” 2010 он, 72-р хуудас

3. $x_1 + x_2 \leq \text{НХ} - 2\text{ЭӨ}$
4. $x_2 \leq \text{НХ} - \text{ЭӨ}$
5. $0,1x_1 \leq \text{ЦА} - 0,1\text{ЭӨ}$
6. $x_1 - x_2 \leq 10\text{ЦА} - \text{НХ}$
7. $x_1 + x_2 \geq 2\text{НӨ} - \text{НХ}$

Судалгаанаас үзвэл уул уурхайн салбарын болоод төлөөлөх компаниуд бидний санал болгож буй балансын зорилгот хэмжээ(бүтэц)-г хангахын тулд:

1. Эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг одоо байгаа хэмжээнээс 80 хувиас доошгүй нэмэгдүүлэх.
2. Богино хугацаат санхүүжилтийн дүнг тус бүр 47 хувиар бууруулах
3. Хуримтлагдсан ашгийн өсөлт, хувьцаа нэмж гаргах болон бусад арга замаар эзэмшигчийн өмчийн дүнг 1.6 дахин нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна.

1-р нөхцөл буюу зорилгын функц нь: Балансын оновчтой бүтцийн тооцоог уул уурхайн салбарын сонгосон 19 компанийн дундажаар авч $\delta_1 x_1 + \delta_2 x_2$ -ийн дүнг хамгийн минимум түвшинд байлгах;

2-р нөхцөл нь: Уул уурхайн салбарын эргэлтийн харьцаа дундажаар 1:1, судалгаанд сонгон авсан 19 компанийн дундаж 0.5 байгааг нормативт түвшин буюу 2:1 гэсэн хэмжээнд хүргэх;

3 ба 4-р нөхцөл нь: Уул уурхайн салбарын хувьд бие даалтын коэффициент 0.12, судалгаанд хамрагдсан 19 компанийн дундаж 0.1, байгааг 0,5-аас багагүй 1-ээс ихгүй болгох;

5-р нөхцөл нь: Өөрийн хөрөнгийн өгөөж нь салбарын болон 19 компанийн хувьд дундажаар (0.1) байгааг 0,1-ээс багагүй байлгах.

6-р нөхцөл нь: Нийт хөрөнгийн өгөөж нь салбарын дундажаар (0.01) хувь, байгааг нэмэгдүүлж 5 хувьд хүргэх.

7-р нөхцөл нь: Гадны капиталын хувийн жин 88,0 хувь байгааг бууруулж 50,0 хувиас ихгүй байлгах.

Хөрөнгө эх үүсвэрийн бүтцийг хангах энэхүү бодлогын шийдийг ашиглан үйл ажиллагаандаа хэрэгжүүлснээр уул уурхайн компаниуд бие даан ажиллах боломж бүрдэх төдийгүй санхүүгийн тогтвортой байдал, хөрөнгийн ашиглалт, нийт болон өөрийн хөрөнгийн өгөөжийн хамгийн бага түвшинг хангахуйц балансын шинэ бүтэц бүрэлдэн тогтох юм.

Хөрөнгө эх үүсвэрийн бүтцийг бүрдүүлэх энэхүү загварыг solver программийн тусламжтайгаар тооцоолсон тул байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамаарч өөрчлөгдөх тохиолдолд дахин тооцоолох боломжтой, бизнесийн байгууллагын удирдлагын нэн чухал арга хэрэгсэл болж ашиглагдана гэж үзлээ.

Судалгааны дүгнэлт

Монгол улсын хэмжээнд 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нийт 113901 аж ахуйн нэгж, байгууллага тушаахаас 89204 аж ахуйн нэгж байгууллага тайлангаа ирүүлснээр ирц 78,3 хувь болж өмнөх оныхоос 7 хувиар өссөн нь сайшаалтай.

Аж ахуйн нэгж байгууллагын хүрээнд үндэсний баялаг бүтээгдэж, санхүүгийн анхны хуваарилалт хийгддэг ААНБ-ын санхүүгийн төлөв байдал нь эдийн засгийн тогтворжилтын суурь үндэс болно. Гэтэл манай аж ахуйн нэгжүүд хэт жижиг, хувьцаат компани цөөн, төрөлжиж хоршоогүй учраас менежментийн сонгодог арга хэлбэрүүд нэвтэрч үр дүнгээ өгөхгүй байна.

2017 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангаа ирүүлсэн байгууллагуудын тоо мэдээлэлд тулгуурлан тооцоолон үзэхэд санхүүгийн хараат байдал нэмэгдсэн, үйл ажиллагааны үр дүн нь жил тутам буурах хандлагатай салбарын тогтвортой өсөлтийн зарчмууд хэрэгжиж чадахгүй байна. Сүүлийн жилүүдэд аж ахуйн нэгж байгууллагуудын дүнгээр өрийн харьцаа нэмэгдэж, хөрөнгийн ашиглалт өгөөж жил дараалан буурч В,С ангилалд хамаарах болжээ.

Нийт аж ахуйн нэгжийн 86 хувь нь 0-100,0 сая төгрөгийн борлуулалтын орлоготой жижиг аж ахуйн нэгжүүд байгаа нь зохистой бүтэц хараахан төлөвшиж чадаагүйг илтгэхийн зэрэгцээ, тэдгээрийн эдийн засгийн өсөлтөнд үзүүлэх нөлөөлөл сул, санхүүгийн харьцангуй “эмзэг байдал”-ын шалтгаан болж байна.

Удирдлагын систем нь удирдуулах (управляемая) систем буюу удирдлагын объект, удирдах (управляющая) систем буюу удирдлагын субъектаас бүрэлдэнэ. Эдийн засгийн шинжилгээний удирдлагын системд эзэлж буй байр суурийг нэмэгдүүлэх бодит шаардлага байна.



Дүрслэл 1. ЭЗШ-ний удирдлагын системд эзэлж буй байр суурь

Дэвшүүлсэн санал

Монгол улсын аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн төлөв байдлын он дараалсан мэдээллийн сан бүрдүүлж, тайлангийн нэгтгэлийг салбараар нь гаргах, санхүүгийн тайлангийн мэдээллийг бодитой, ил тод нээлттэй байдлыг хангах замаар эргэлтэнд оруулж, санхүүгийн тогтворгүй байдалд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг дотоодын болон хамтарсан, гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд гэх мэт ангилал тус бүрээр судалж дүгнэлт өгөх, салбарын бодлогыг тодорхойлох шаардлага тавигдаж байна.

Бүртгэл санхүү эдийн засгийн ажилтны улсын VI зөвөлгөөний зөвлөмжинд “Аж ахуйн нэгж, байгууллага бүр санхүүгийн тайлагналаас нэгдмэл тайлагналд шилжих асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх” гэж тодорхойлсоны дагуу байгууллага бүрийн нэгдмэл тайлагналд Сангийн сайдын 2015 оны 343 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал”-ын дагуу шинжилгээ хийж, үр дүнг үйл ажиллагаандаа хэрэглэдэг байх шаардлагыг оруулж өгөх нь зүйтэй юм.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих стратегийг үргэлжлүүлэх нь агуулгын хувьд зөв боловч хүртээмжтэй өсөлт талаас нь анхаарч хөгжүүлэх шаардлагатай. Тухайлбал хөдөө орон нутагт өндөр технологид суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэх, аж ахуйн нэгж байгууллагын тоонд бус чанар, үр ашигт анхаарах, хүн амын хэт төвлөрлийг сааруулах бодлогыг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх бодлоготой нягт уялдуулах, бүс нутгуудад үйлдвэрлэлийг дэмжсэн бодитой бодлого боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Ашигласан материал

- [1]. Б.Сайнжаргал, 2009, Санхүүгийн дунд шатны бүртгэл- II, номны 23-р бүлэг, 693-699 хуудас, Хөх судар принтинг ХХК, Улаанбаатар.
- [2]. Л.Наранчимэг, 2011, Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээний онол, арга зүйн асуудал, Широ принт ХХК, Улаанбаатар.
- [3]. Савицкая Г.В, Москва 2006, Методика комплексного анализа хозяйственной деятельности, Изд-во Проспект, Москва.
- [4]. PODKAMINER Leon. “Labor productivity growth slowdown: an effect of economic stagnation rather than its cause” Vol 672017, sup:1 pp 67-77
- [5]. ENKHSAIKAN.S “Management of Productivity of the State”, Ulaanbaatar, 2012, KITON printing pp 126-130
- [6]. A Note on Economic Order Quantity Model DOI: 0.4236/Ib.2017.94006 <https://www.scirp.org/journal/paperinformation.aspx?paperid=80888>
- [7]. Financial Reporting: Long-Term Change of Financial Ratios DOI: 610.4236/ajibm.2018
- [8]. 89128 <https://www.scirp.org/journal/paperinformation.aspx?paperid=87112>
- [9]. Монгол улсын статистикийн эмхэтгэл, 2007- 2018, Улаанбаатар.
- [10]. СнЯ.Нягтлан бодох бүртгэлийн газар “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн нэгтгэл” 2013-2018 он
- [11]. “Аж ахуйн нэгж байгууллагын бүтцийн өөрчлөлтийн дүн шинжилгээ”: Монгол улсын үндэсний статистикийн хороо 2017 он

Электрон эх үүсвэр:

- [1]. Монголын хөрөнгийн бирж: <http://www.mse.mn/companies/mfinance2012>
- [2]. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо: http://www.nso.mn/v3/index.php?page=news_list
- [3]. Монгол улсын сангийн яам: <http://www.mof.gov.mn/page/form?lan=mn&c=30707>
- [4]. “Финансы и кредит” журнал: <http://www.fin-izdat.ru/journal/analiz/>
- [5]. “Аудит и финансовый анализ” журнал: <http://www.auditfin.com/>